



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 8/66

Чингис хот

Д.Жамбааг Батноров сумын  
Засаг даргаар томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны "Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ" 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5, 26.5.1, 26.5.2, 26.5.3, 26.5.4, 26.5.5 дахь заалтад заасан шаардлагыг хангасан Доржоогийн Жамбааг Батноров сумын Засаг даргаар томилсугай.

2. Сумын Засаг дарга Д.Жамбаагийн үндсэн цалинг 1052207 /нэг сая тавин хоёр мянга хоёр зуун долоон/ төгрөгөөр, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар болон бусад нэмэгдлийг тооцож цалинжуулахыг Батноров сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй

3. Д.Жамбаад томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ харьяа Эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010998